

**Монголын сургаалын зохиолууд дахь эдийн засгийн
үзэл санааг тоймлох нь**

Төмөртогоо Даш.

Сургаалын зохиол гэдэг нь Монголын уран зохиолын нэгэн төрөл зүйл юм. Сургаалын зохиол нь тухайн нийгэм дэх гаж буруу үзэгдлийг шүүмжлэн, хүнд зөв зөвсгөөр хүмүүжлийг олгоход чиглэсэн ёс суртахууны сурах бичиг, зөвлөмж гэж үзэж болмоор уран яруу хэллэгтэй зохиолууд байдаг. Монголын сургаалын зохиол нь хүүрнэл зохиол, шүлэглэсэн сургаал хэлбэртэй байх ажээ. Монголын сургаалын зохиолууд дахь нийгэм-эдийн засаг, улс төр, ёс суртахууны үзэл санааны асуудлыг өнөө хэр тусгайлан судласан бүтээл хараахан үгүй байна. Харин уран зохиол судлаач акад. Ц.Дамдинсүрэн, Д.Цэрэнсодном нар сургаалын шүлэглэсэн зохиолуудыг нягтлан шүүрдэж алдаагүй бүрэн сайн эхийг нийтлүүлэх, уран зохиолын төрөл зүйлийнх нь хувьд судлан шүүмжлэх талаар зүйрлэшгүй ихийг бүтээжээ. Энэ талаар Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын тойм” I,II дэвтэр, Д.Цэрэнсодномын “Монголын уран зохиол” /XIII-XX зууны эхэн/ зэрэг бүтээлээс тодруулан үзэж болох юм.

Монголын сургаалын зохиолыг судласан Д.Цэрэнсодном монголын сургаалын шүлгүүдийг :

- Эртний баатарлаг явдал, эр зоригийг бадруулсан дайчин хэлбэрийн шүлэг, сургаал
- Бурхны шашны нөлөө багатай жирийн амьдралын сургаал
- Бурхны шашны сургаалыг номносон хоосон чанарын сургаал гэсэн үндсэн гурван бүлэг болгож үзжээ.

Бидний үзсэн сургаалын хүүрнэл зохиолууд ч мөн энэ гурван ангилалд хамаармаар төрхтэй байлаа.Тэгэхдээ олонхидоо хоёр ба гурав дахь ангилалд багтах буюу энэ хоёр шинжийг хамтатгасан агуулгатай байв.Нэгдүгээр ангилалд хамаарах сургаалын хүүрнэл зохиол тааралдсангүй. Харин гурав дахь ангилалд багтах шашны элдэв сургаалыг жичид нь тусгайлан үзвээс зохих хэмээн энд хөндсөнгүй.

Монголын сургаалын зохиол нэн эртний улбаатай юм. Анх аман сургаалын хэлбэрээр хэлэлцэгдэж улмаар бичмэл зохиолд орж ирсэн нь лавтай. Тиймээс монголын

сургаалын зохиолыг ардын аман зохиолоос эхтэй гэж үзэхэд буруудах зүйл үгүй болой. “Монголын нууц товчоо”-нд шүлэглэн холбосон сургаалын чанартай мөр бадаг цөөнгүй байхаас үзвэл лавтайяа мянгаад жилийн өмнөөс эхтэй гэж хэлж болох буй заа. Мөн орчуулгын зохиолын нөлөө ч бага бус. Энэтхэг, Төвдөөс бурхны шашны уран зохиолыг орчуулсаны нөлөөгөөр үүссэн сургаалын зохиол цөөнгүй байдаг. Д.Цэрэнсодном “ХIII зууны үед баатарлаг явдлыг явдлыг талархан сайшаасан шүлэг, сургаал зонхилж байсан бол ХVIII зууны үеэс бурхан шашны нүгэл, буян, хүлцэнгүй чанарыг номносон шинэ агуулга бүхий шүлэг сургаал голлох суурийг эзлэх болсон /Д.Ц. 1987-272/ гэж үзсэн байна. Сургаалын шүлэг нь түүний үзэж буйгаар ХIV зууны эхэн үеэс уран зохиолын бие даасан төрөл зүйлийн шинж төрхийг олж Энэтхэг, Төвдийн сургаалын шүлгийн нөлөөн доор хөгжиж /Д.Ц. 1987-189/ иржээ.

Шүлэглэн зохиосон сургаалын тоонд Чингис богдын сургаал гэгдэх “Оюун түлхүүр” /ХIV зуун /, зохиогдсон он цаг, зохиогч нь тодорхойгүй гэдэг “Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг”, Райдэн Янгонбагийн дахин төрсөн хувилгаан гэгч 1784 он орчимд зохиосон бололтой гэгдэх “Сургаалын үгс тод сарны гэрэл” хэмээх шүлэг, Жавзандамба богдын тавдугаар дүр Цүлтэмжигмэд зохиосон “Орчлонгийн сав шимийн дуулал” /1840- ?/, Тобагийн гэгээний зохиол “Тоть шувууны сургаал” /он цаг тодорхойгүй/, Урад хошууны гэгээн Лувсандамбажанцан зохиосон /1730-1780/ “Мэргэн гэгээний сургаал”, Н.Ишданзанванжилын “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал оршивой” /ХIX зууны эцэс/, Говийн догшин ноён хутагт Данзанравжаагийн /1803-1856/ зохиосон олон сургаал шүлгүүд зэргийг нэрлэж болно.

Эдгээрээс гадна Энэтхэг, Төвдөөс орчуулсан Нагаржунагийн “Ардыг тэжээх рашааны дусал”, Сажа бандид Гунгаажалцаны “Эрдэнийн сан Субашид”, Төвдийн эрдэмтэн Банчин Содномдагвын зохиосон “Цагаан лянхуан баглаа” гэх мэт бурхны шашны сургаалыг шингээсэн яруу сайхан хэллэг бүхий сургаалын зохиол, Панчатантра буюу “Таван сургамж”, “Дармапада”, “Уданабарга” зэрэг бурхны шашны сургаалын орчуулгууд бий юм. Мөн хятад хэлнээс бүр ХIY зуунд орчуулан барласан Күнзийн сургаалын “Ачлалт ном” гэдэг ном ч байдаг. Эдгээр зохиол монголд маш их дэлгэрч тодорхой нөлөө үзүүлсэн гэж үздэг.

Монголын уран зохиолд сургаалын шүлгээс гадна сургаалын хүүрнэл зохиол нэлээд бий юм. Бидэнд мэдэгдэж буйгаар эдгээр нь уран зохиол гэхэд таарамжтай биш, гол сэдэв, зохиолын баатар, үйл явдлын өрнөлгүй их төлөв хүмүүжил, ёс суртахууны сургаал, нэлээд нь аж ахуй, эдийн засгийн чанартай ухуулга, сургаал байдаг. Тийм зохиолд “Богдын сургаалын сэнхрүүлэн бадруулсан бичиг” /1724 он /, Хэбэй Ван Бат-очирын Тогтохтөрийн “Аж төрөхийг заасан сургаал” /1853 он/, Хардал жанжин бэйс засаг Мижүрдоржийн * Пүрэвжавын зохиосон “Харъяат хошууны дотор дагаж явуулахаар тогтоон тушаасан ухуулах бичгийн эх” /1885/, Дандаа чинсан гэгдэх Чимидийн Дэмчигдоржийн “Эрдэнэт толь хэмээх шастир” /1913 он/, Тарав бандидын зохиосон “Ард түмний ариун ёсон” /1923 он/, Ч.Бат-Очир бичээчийн туурвил “Мандах нарны туяа” /1926 он/ зэрэг бүтээлийг нэрлэж болох байна.

* Хардал жанжин бэйс Пүрэвжав буюу олонд “Өвгөн ноён” гэж алдаршсан их уяачийн эцгийн алдарыг хуучин зарим номд Минжүүрдорж, Миноүрдорж гэх мэтээр бичиж байсан боловч судлаачид **Мижүрдорж** гэж олж тогтоосон байна.

Монголын сургаалын зохиолын эдгээр төрөл бүхнийг нэгтгэн судалсан бүтээл өнөө хэр бидэнд олдсонгүй,. Энэ удаа бид гаднаас орчуулсан зохиолуудыг хөндөлгүй монголын сургаалын зохиолууд дахь эдийн засгийн сэтгэлгээ, үзэл санааны асуудлыг нь цоолдон авч үзэхийг хичээв.

“Монголын уран зохиол” гэдэг томоохон бүтээлээ акад. Д.Цэрэнсодном 1987 онд хэвлүүлэн бүхий үед Равжаагийн зарим бүтээлийн зохиогч нь тодорхойгүй байсныг Д.Цагаан тодруулж 1992 онд нийтлүүлсэн “Яруу найргийн цоморлиг” бүтээлд хэд хэдэн хувилбарыг харьцуулан тодосгож оруулсан бий учраас Равжаа хутагтын “Сургаал” нэртэй зохиолын тоо арав гаруй болжээ. Эдгээр нь монголын сургаалын шүлгийн дотор томоохон суурийг эзлэх юм.

Д.Равжаа хутагт монгол, төвд хоёр хэлээр олон сургаал зохиож байсны дотор “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу”, “Сэтгэлийг амраагч”, “Хавар цагийн зугаа”, “Оюун толь”, “Олон хөгшид хүүхдийн хэлэлцдэг үгсийн товч” зэрэг томоохон сургаал цөөнгүй. Равжаа хутагтын зохиол бүтээл дэх эдийн засгийн сэтгэлгээний асуудлыг жич авч үзсэн /Ноён хутагтын сургаалын аврахуй ачлал УБ., 2003.94-126 талд / тул энд оруулсангүй.

Монголын сургаалын зохиолын уламжлал ардын засгийн жилүүдэд ч үргэлжилсээр байсны дээр ардын төрийн зүгээс энэ талаар анхаарч байсан гэж үзэж болно. Маршал Чойбалсангийн хэлж дургасанаар Жамсрангийн Самбуу 1940 онд бичсэн “Мал аж ахуй дээрээ хэрхэн яаж ажиллах тухай сануулга, сургаал” гэдэг томоохон зохиол үүний гэрч болно. Энэ зохиолыг хэвлүүлэхэд төрөөс ихээхэн анхаарал тавьж, ид дайны дундуур хэвлэлийн мэргэжлийн хүнийг Москва хотноо илгээж үсгийн хэв цутгалт, өрөлт, хэвлэлтийг дагнан гүйцэтгүүлж монгол үсгээр хэвлэсэн байдаг. Энэ ажлыг гардан хийсэн хэвлэлийн ахмад ажилчин Дашлэгцэг гуайд Ж.Самбуу гуай өөрөө номоо дурсгалын үгс бичиж дурсгасан байдаг юм. Тэр үед Ж.Самбуу гуай ЗХУ-д манай улсаас суух онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд байжээ. Энэ бүтээлийг 1987 онд кирилл үсгээр шинээр хэвлэж гаргасан буй.

Үүнээс гадна тэр үеийн нэгэн содон бүтээл бол Өөлд мэйрин буюу Говийн Дорж мэйрин гэж нэршсэн Бунибазарын Дорж агсаны зохиосон “Малчнаа сануулах сэдэв” гэгч сургаалын зохиол/1934он/ болно. Эдгээр нь мал аж ахуйгаа эрхлэн өсгөх мэдлэг дадлага олгоход зориулан монголын сургаалын зохиолын уламжлалаар бүтээсэн зохиол болой. Чухамхүү тэр үед манай мал аж ахуйд басхүү өөрийн малаа маллан өсгөхийг чармайж буй шинэ малчин ардын аж ахуйтны нэгэн шинэ үе өсөж өндийж байсан цаг болно.

Бид монголын сургаалын зохиолын уран сайхны тал, зохиомж, яруу хэллэг /зохист аялгуу/ мэтсийг огт үл хөндөн зөвхөн эдийн засгийн үзэл санааны талыг нь тоймлон үзэхийг хичээв. Энэ нь монголын хуучин уран зохиол дахь эдийн засгийн үзэл санааны асуудлыг хөндсөн анхны оролдлого тул өнгөц, товч, дулимаг байгааг эрхэм судлаач, уншигчид өршөөн болгоох буй заа.

Нэг.Сургаалын хуурнал зохиолуудыг хөндсөн нь:

Монголын сургаалын зохиолоос бидний үед уламжлан ирж чадаагүй он цагийн эрхээр үрэгдэж алдарсан нь цөөн бус. Сургаалын зохиол бичсэн мэргэд өнөө бидэнд олдохгүй болсон нэг бус зохиолын нэрийг дурдаж, ашигласан хэрэглэсэн гэж өгүүлсэн буй.

Бидэнд олдсон сургаалын зохиолын эртнийх нь 1724 онд зохиож хэвлүүлсэн **“Богдын сургаалыг сэнхрүүлэн бадруулсан бичиг”** юм. Манжийн төрөөс монголыг эзлэн талхихаар цэрэг улс төр, эдийн засаг, хууль цааз, шашин суртал, ёс суртахууны иж цогцолбор холч гүн бодлого боловсруулан нарийн дэс дараатай хэрэгжүүлж байжээ.

Манж нар Монголыг Өвөр, Ар, Баруун гурван хэсэг болгож 1638-1750-иад оны хооронд гурав таслан залгисан юм. Тэд монголчуудыг хооронд нь дайтуулах, өөрөө цэрэглэх, цааз хуулиар хавчих, сувдаг ноёдод цалин пүнлүү өгч хахуульдах, гүнж хатад өгч бугуйлдах, албан татвараар дарамтлах элдэв арга явуулга хийдэг байжээ. Энэ явуулгыг дотор “бичгийн ухаан”-аар ятган эзлэх бодлого ч тодорхой байр эзлэнэ.

“Богдын сургаалыг сэнхрүүлэн бадруулсан бичиг” бол Өвөр монголыг Манж улс эзлэсэнээс 28 жилийн дараа анх мөрдүүлж улмаар Ар монголыг дагуулсанаас 33 жилийн дараа улам өргөтгөн нягтлаж манжийн төрөөс монголчуудыг номхон хүлцэнгүйгээр захирагдан аж төрөхийг ятган ухуулсан сургаалын зохиолын хэлбэрээр 1724 онд манж, монгол хэлээр, хожим хятад, төвд хэлээр нэмэн барлаж удаа дараа тархааж байсан зохиол юм.

Уул сургаал нь бүхэлдээ 16 зүйлээс бүрдэх бөгөөд олонхид нь аж төрөхүй, арвилах гамнахыг заасан сургаал агуулагдсаны дотор “Арвилах хурхаглахуйг эрхэмлэж, эдийн хэрэглэхүүнийг хайрлахуй нь” нэрт 13 дугаар зүйл нь шууд эдийн засгийн агуулга бүхий юм. Бусад зүйл бүлэгт ч эдийн засгийн агуулга бүхүй үг өгүүлбэр цөөн бус.

Бид энэ зохиолыг хэдүй Манжийн төрөөс батлан албадаж мөрдүүлэхээр тархааж байсан боловч монголын уран зохиолын уламжлалыг сайтар судлан ашиглаж зохиосон монгол мэргэдийн сургаал гэж үзэж байгаа юм. Манжийн төрөөс батлан мөрдүүлсэн “Монгол цаазын бичиг” ч мөн монголын хууль цаазны бичгийн уламжлалыг нягт хуулбарлан хэрэглэсэн байгааг судлаачид дурдсан байдаг /Монгол цаазын бичиг.2004-7/. 1638 онд Өвөр монголыг эрхшээлдээ авсан даруй “Монгол цаазын бичиг” гэгч хууль цаазны бичгийг боловсруулж эхлэсэн бололтой бөгөөд түүнээ 1667 онд батлан мөрдүүлсэн байна. Дараа нь Ар Монголыг 1691 онд, Баруун монголыг 1750-иад онд эзлэн авч хууль цаазны бичгийг улам нарийвчлан боловсруулж 1794 онд батлан мөрдүүлсэн байдаг. Чухамхүү ингэж “Бичгийн ухаан”-аар эзлэхийн нэгэн бүрдэл нь монгол мэргэдийн зохиосон сургаалыг Манжийн хааны зарлиг болгож хэвлэн тархаасан энэхүү сургаалын зохиол юм .

Энэ сургаалд “Хүн аж төрөхөд нэгэн өдөр ч болон эд үгүй болбаас үл болно. Тийн хэмээвч эрхгүй илүүхэн үйлдсэнээр хойно сая тасралгүй хэрэглэхээр нийлүүлж болно. Иймийн тул арвилан хурхаглах /Гамнаж хуримтлуулах гэсэн үг. Д.Т/-ыг эрхэм болгожээ. Эд хэмээгч ус лугаа адил. Усны урсгалыг эс халхлаваас зоргоор урсаж

одсоор үл үлдэхийн тул ус агшин зуур ширгэнэ. Эдийн гарлагыг эс хэмнэвээс хэрэг нь хэмжээгүй тул эд эгшин зуур барагдана” хэмээжээ. Өөрөөр хэлбэл, аж төрлийг залгуулахын тулд зөвхөн тухайн хэрэгцээг хангах төдий үйлдвэрлэл эрхлэх бус ямагт хуримтлалыг бий болгож, нөхөн үйлдвэрлэлийг явуулж байх, басхүү хэрэглээндээ ямагт арвилан хэмнэхийг гол болгож сургасан байна. Хэрэглээг эс хямгадах нь усны урсгалыг эс халхлахын адил болно гэж тов тодорхой өгүүлсэн нь монголчуудын угийн сэтгэхүйд нэлээд нийцтэй болсон хэрэг юм. Ер нь хэрэгцээний хэрээр урсгах бус, ямагт хямгатай зөв ухаалаг хэрэглээг гол болгох сургаал монголын сургаалын зохиолуудад байнга тохиолдоно. Энэ нь бурхны шашны сургаал, өөрсдийнх нь ахуй байдалтай нэн зохицсон сургаал болно. Тиймээс ч энэ санааг дараа дараагийн зохиогч нар сургаалдаа ямар нэгэн хэлбэрээр давтан өгүүлсэн байдаг

Дандаа чинсан. “Эрдэнэт толь”

“Бурхны их хөлгөн номын журмыг батжуулсан ертөнц дахиныг сургах эрдэнэт толь хэмээх шастир” буюу товчоор “Эрдэнэт толь” гэдэг сургаалын хүүрнэл зохиолыг зохиогч нь Чимидийн Дэмчигдорж /бичгийн алдар нь Дандаа чинсан.1863-1932/ болой.

Тэрээр 1863 онд өнөөгийн Өвөрмонголын Зостын чуулганы Харчин дундад хошууны нутагт харчин овогт Чимидийн гэр бүлд төрж өсжээ. Тэр монгол, хятад хэл бичигт нэвтэрхий суралцаж манж, төвд, япон хэл бичиг эзэмшсэн гүн ухаантан, соён гийгүүлэгч, нийтлэгч, орчуулагч байв. 1904 оноос Бээжин хотноо хэвлэгдэн гардаг байсан “Да гүн Бао” сонины Монгол, Төвд, Хотон үндэстний асуудал эрхэлсэн түшмэл-сэтгүүлч, хожим нь мөн сонины Чуулалт хаалган хотноо суух сурвалжлагч 1912 оноос Сөнид замын цэрэгт, дараа нь Цахар найман хошуу ба Жа сян гуу-гийн ногоон тугийн манж- монгол цэргийн түшмэл, цэргийг Бүгд Захиран Шийтгэх Яамны зөвлөн хэлэлцэх түшмэл зэрэг алба хашиж явжээ. Түүнийг ийнхүү сэтгүүлчийн хийгээд цэргийн албаныг хааж ахуйд Манжийн төр мөхөж монгол түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл биелэлээ олж Монгол орон тусгаар тогтнолоо зарласан байна. Чухам тэр үед монгол үндэстний тэргүүний сэхээтэн олон хүн Буриад монгол, Өвөр монголоос Монгол голомтдоо хүчнээ өгөхөөр зүтгэн ирж байсны нэг нь Дандаа чинсан буюу Дэмчигдорж юм. Тэрээр тусгаар тогтнолоо олж сэргэн мандсан шинэ монголд хүчин зүтгэхээр 1914 онд Ар Монголд ирсэнд Богд хаант төрөөс түүнд одоогийн Төв аймгийн Аргалант сумын төвөөс зүүн хойно Жирмийн цагаан нуурын орчимд нутаг олгон суулгажээ. Дандаа чинсан Халх нутагт ирж бичиг эрдмийн ажлаараа тулгар төрөө мандуулсан шинэ монголын төрд хүчээ өгч байсны дотор “Юан улсын судар” гэдэг 210 дэвтэр сурвалжийг хятад хэлнээс орчуулсаны дээр “Шинэ засгийн зүйл”, “Шинэ засгийн гол ёсон” зэрэг бэсрэг зохиол бичиж, Нийслэл хүрээний сонин бичиг, Шинэ толь зэрэг тогтмол хэвлэлүүдэд “Гэмээ мэдсэн хөдөөний хүн” нэрээр хэвлэн нийтэлж байв. Дандаагийн бүтээлийг гол нь энэхүү “Эрдэнэт толь” болно.

Он цагийн байдлыг хянаваас “Эрдэнэт толь” зохиолоо Дандаа чинсан өвөрлөгч нутгаас ирэхээсээ өмнө бичсэн бололтой гэмээр сэжүүр бий. Бид энэ зохиолын доторх эдийн засгийн үзэл санааг анх удаа хөндөхийг оролдов. Ер нь Дандаа чинсангийн бүх бүтээлийг нэгтгэж тусгайлан судалсан буюу эдийн засгийн үзлийг нь ангид ялгаж хөндсөн бүтээл одоогоор орж үзээгүй байна. Харин Ч.Жүгдэр, Д.Дашжамц, Л.П.Попова,

Д.Дашбадрах зэрэг эрдэмтэд түүнийг үндэсний сэхээтэн, дэвшилт ардчилсан үзэлтэн, нийтлэлчийнх нь хувьд удаа дараа дурдаж байсныг үзэж болно.

“Эрдэнэт толь” сургаал нь саяхныг хүртэл нийтийн хүртээл болоогүй Улсын төв номын санд гар бичмэлээр хадгалагдсаар ирсэнийг Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн түүхч эрдэмтэн Доржготовын Дашбадрах кирилл үсэгт буулгаж 1995 онд Улаанбаатар хэвлүүлэв. Харин хэвлэгдсэн тоо тодорхойгүй. Бид энэ эхийг баримтлан гол хэрэглэгдэхүүн болгов. “Эрдэнэт толь” гэдэг “Сургах шастир” зохиол нь нийт дөрвөн том дэвтэр, жаран дөрвөн бүлэг бүхий зохиол юм. Тэдгээр бүлэг бүхэн дорно дахины уламжлалт ном зохиолын адилаар өөр өөрийн утгыг товчилсон гарчигтай юм. Жишээлбэл, “Мэргэн ард нь мунхаг ардыг жолоодохуй арван долдугаар бөлөг” гэх мэт болой.

Бид эдгээр 64 бүлгийг нэг бүрчлэн дурдахгүй зөвхөн эдийн засгийн агуулга бүхий хэсгийг нь товчлон цоолдож авч үзнэ. Уул зохиол нь бурхны шашны гол номлол сургаалыг тухайн цаг үеийнхээ бичгийн хэлээр тайлбарлан өгүүлэхийн дээр жирийн амьдралын зөвсүгэй зөөлөн ёс суртахууныг хичээнгүйлэн номлосон зохиол юм.

Тэрээр өөрөө энэ сургаалыг зохиох болсон зорилгоо тодорхойлохдоо “...Олон улсын ёсыг шинжлэвээс, тэдгээрийн язгуурын суртахууны ёсонд болбоос сайтар сахих хийгээд унших, орхих ба дагаж явах сургаал соёлын дүрэм хэмжээ тодорхой бөгөөд бас тогтсон дүрэм бүхий нь тул, тийнхүү гэрээс гарсан ардаас /лам хуврагаас гэсэн үг юм.Д.Т/ эрэгтэй эмэгтэйд хүртэл их бага нэгэн адил нэгэн ёс, нэгэн сэтгэлгээтэй бөгөөд нэгэн нэгэндээ янаг найртай бөгөөд харилцан хор хөнөөлгүйгээс гадна, жич өөр зүйлийн суртахууныг дагана. Энэ нь дүрэм чанга тодорхойн учир буюу... бидний Бурхны суртахууны улс болбоос гагцхүү гэрээс гарсан ардад ёс сургаал тогтсон дүрэм бүхийгээс бус ... нийгэм тухайд сургаал соёл хийгээд тогтсон дүрэмгүй, ер хүн амьтанд сургаал соёлгүй ухаан болбоос ухаан нээгдэхгүй, тогтсон дүрэмгүй болбоос журамлан дагах дүрэм хэмжээгүй. Ер хүний ёсонд ухаан нээгдэхгүй болбоос нэгэн мунхаг хүн бөгөөд дүрэм хэмжээгүй болбоос бас ч нэгэн балай хүн тул үүнд баян чийрэг болохыг хаанаас олно” гэжээ. Чухамдаа бол гадаад олон улс тус бүр нэгдсэн нэг хууль журамтай түүнийгээ лам, хар эр, эмгүй мөрдөж байдаг юм байна. Манайх болохоор зөвхөн лам нарыг нь бурхны сургаал ёсоор явахыг шаарддаг болохоос бусад нь нэгдсэн хууль, ёс суртахуунгүй байна. Түүнээс шалтгаалж хүний ухаан нээгдэхгүй, бас балай /сохортой адил гэсэн үг Д.Т/ байна. Ингэхлээр мунхаг, сохор хүн яаж баян чинээлэг болох юм гэж шүүмжилсэн байна. Тэгээд үүнийг залруулахын тулд “...Өтгөс би шашин төрийг хамтаар тэтгэх санааг гол барьж, бас их олноор дүрэм адилшаахыг хүсэж, өөрийн мунхагаа огт үл бодон... хамаг бүгдийг ангижруулан сайнд хүргүүлсүгэй хэмээн санаж, хичээнгүйлэн Бурхны номоос аль ертөнцийн ёсонд холбогдсон эл зарлигуудыг эши татаж тус тус дэлгэрүүлж ангид ангид сургаал болгон зохиогоод...судруудаас хэдэн зүйлийг чухал номлолыг ялган авав” гэжээ.

Тэгээд өөрийн бүтээлээ “Үнэхээр шашин төрийг хамтаар тэтгэх чухал сургаал тул аливаа лам нар, эрэгтэй эмэгтэй ч ялгахгүй бүгдээр уншваас зохино” гэжээ.

Дандаа чинсан тэр үед байтугай өнөө ч гологдохооргүй их гүн мэдлэгтэй, гадаадын хэд хэдэн хэлтэй боловсрол сайтай байсны улмаас дэлхий дахины байдлыг нэлээд нарийн мэдэж, түүнийгээ өөрийн улсын аж амьдралтай жишин улс орноо

хөгжүүлэхийн тулд өөрийн мэргэжил, боловсролын дагуу зүтгэж бүтээсэн нь энэ зохиол ажээ.

Тэрээр бичихдээ "...Ертөнцөд бүхий түмэн улс цөм элдэв зүйлийн мэргэн чадлыг эрхэлсэн цаг тулд үүнээс зүйл бүрийн сонин гайхамшиг эрдмүүд дэлгэрсэнээр, тэдгээрийн улс баян чийрэг бөгөөд басхүү өдөр бүр улс нарийнаас нарийн болгож, шаламгайлан хичээнэ. Аяа, хэрвээ бидний суртахууны улс үүнийг мэдэхгүй, хуучин хэвийг баримтлан сахиж, цаг учралд нийлүүлэн зүтгэлийг үзэж, сайн болгож халах ба шинэтгэж засахыг мэдэхгүй болбоос, мөхөж сөнөх нь нүдний өмнө болсон тул өтгөс би үүнд тэсгэл үгүй айж" буйгаа илчлэн энэ сургаалыг зохиосон байна.

Дандаа чинсангаас даруй зуун жилийн хойно энэ мөрийг тэрлүүлж бүхүй цагт дэлхийн тэргүүний хөгжилтэй улсуудад үхрийн шир, нэхийний өөдөснөөс эсийг авч төлжүүлэн үхэр хонь бүтээх болсон байхад бид өвөл (2001 онд) зуд ирж хуц ухна цөөрсөний улмаас хээлтүүлэгч хүрэлцэхгүй байгаа тухай ярьж бичсээр суугаа билээ. Эсийн үржүүлгийн тухайд хэрээс хэтэрсэн зүйл байж гэхэд хөлдөөсөн үр хэрэглэх зохиомол хээлтүүлэг хийх хэмжээнд эрхбиш хүрсэн байтлаа түүнийгээ өргөн хэрэглэхгүй түмэн жилийн өмнөх аргаараа ухна хуцны аясаар мал аж ахуйн үржлийн ажлыг эрхлэн буйгаа хэвийн зүйлд бодож "экспортын баримжаатай эдийн засагтай болж дэлхийн зах зээлд өрсөлдөх" мөрөөдөлд умбах ажээ.

Дандаа чинсан өөрийнхөө бүтээлийн эцэст хорин дөрвөн зүйл бүхий "Тогтсон дүрэм" гэгч дагаж хэрэгжүүлбээс зохих заавар дүрэм хавсаргаж эхний зүйлд нь "Сүмийн дэргэд тусгай гэр барьж хөвгүүд, охидыг долоон нас хүрмэгц цуглуулан авчирч тус тусад цагаан толгой хийгээд бага сага үсэг таних хялбар шастир таниулаад дараа нь Эрдэнэт толь уншиж дүүрсэний хойно лам болох нь сүмд очиж хар бологчид хийгээд охид нь өөр өөрийн авьяас дурыг дагаж эмч, зурхайч, урлах эрдэм, цэрэг, худалдаа, тариалан үйлдэх тэргүүтнийг суртугай" гэж зааварчилсан байдаг. Үүнээс үзвэл "Эрдэнэт толь" сургаалыг суурь боловсролын ёс суртахууны сурах бичиг болгож зохиосон бололтой.

Дандаа чинсан "Эрдэнэт толь" бүтээлээ "Бурхны Их Хөлгөн номын журмыг батжуулсан ертөнц дахиныг сургах шастир" хэмээн нэрийдсэн нь дэмий гоёчилсон бус тэрбээр Бурхны шашны Их Хөлгөн-Махаяна урсгалыг баримтлан шашин суртахууны хүмүүжлийг нийтэд олгохыг гол болгон бичсэн байдалтай юм. Номын олонх зүйл нь бурхны шашны гол баримтлалуудыг тайлбарласан бөгөөд хувраг биш, эгэл олон ардад бурхны шашны сургаалыг эзэмшүүлэхэд чиглэсэн байна.

Дандаа чинсан бол бурхны шашинтан, их хөлгөний сургаалыг түгээгч мөн гэдэг нь түүний бичсэн сургаалаас тодорхой ажээ. Тэрээр "доорд, баян үгээгүү хийгээд жаргах зовох тэргүүтэн нь зүйл зүйлээр асар тэгшгүйгээр аж төрж ирнэ. Зарим нэгийг муу зовлонт болгон төрүүлээд бас доорд дээр доорд, үгээгүү дээр үгээгүү болгож элдэв зүйлээр мохоож зовооно... Үүний учир бүхнийг олж мэдвээс болох нь жич үйлийн үрээс өөр хэнд харьяат болно" гэжээ. Өөрөөр хэлбэл ингэж баян үгээгүү төрөх нь гагцхүү "үйлийн үрээс болно" гэсэн байна. Үйлийн үр / карма / гэдэг нь бурхны шашны нэгэн чухаг баримтлал бөгөөд аливаа хүн хийсэн бүх үйл хөдлөлийнхөө үрийг амсах ёстой бөгөөд үйлдэл бүхний үр хэзээ боловч боловсрон эзэндээ эргэж нөлөөлдөг гэдэг өнөөгийн ойлголтоор бол шалтгаан үр дагаврын уялдааны тухай номлол юм. Гэхдээ үйлийн үр нь зөвхөн нэгэн насны үзэгдэл бус хэн хүний урьд насны үйлийн үр нь энэ

буюу хойд насанд илэрч боловсорч болдог гэж номлодог. Тиймээс хэн боловч хойд насандаа муу үйлийн үрийг амсахгүйн тулд энэ насандаа ямагт сайн үйлийг үйлдэж байхыг номлодог. Өнгөц санахад хэн ч үзээгүй, үзэх ч үгүй хойд насны тухай хуурамч номлол мэт боловч нөгөө талаар бодвол хүнийг элдэв муу үйлээс ангид байлгаж зөв аж төрөхөд чиглүүлсэн хүмүүжлийн ач холбогдолтой сургаал мэт харагддаг.

Дандаа үйлийн үрийг товч тодорхой хэлсэн нь “...Адилтгаваас, тариалангийн хүн хаврын цагт хичээж, ямар үрийг сацваас, намрын цагт тэрхүү сацсан ёсоор хураан авах мэт” гэжээ. Тэгэхдээ үйлийн үр нь гурван янз, нэгд, одоо сайн муу үйл үйлдээд, одоо жаргах зовохыг эдлэнэ, хоёрдугаар нь,... Урьд төрөлд үйл үйлдээд, одоо жаргах зовохыг эдлэнэ. Эс бөгөөс энэ төрөлд үйл үйлдээд хойд төрөлд эдлэнэ. Гуравдугаар нь, үйл хурдан боловсроно. Нүдний өмнө үйл үйлдээд нүдний өмнө эдлэнэ” хэмээжээ. Тийнхүү “сэцэн гэгээн, мунхаг тэнэг, хүчирхэг үхээнц буурай, сайхан муухай, жаргах зовох, амух /амрах/ зүдэх нь зүйл зүйлээр адилгүй, цөм өөр өөрийн үйлдсэн сайн муу үйлийн үрийг дагаж боловсрон тасрана” гэжээ.

Гэхдээ ингэж өөрийн урьд ба энэ төрөлд хийсэн үйлийн үрээр баян үгээгүү, сэцэн мунхаг, хүчирхэг буурай болон төрөвч түүнийгээ өөрөө хичээн засамжлаж эсвэл бүр муутгаж болох юм гэнэ. Тухайлбал, “Тийнхүү сэцэн мэргэн, баян эрхэм зэрэг хүчин бүхүй ард сайныг цугларуулахыг үл мэдэн, гагцхүү одоо бүхүй буяндаа эрэмших болбоос урьд төрлийн хураасан буяны хөрөнгө улам саарч барагдаад, мунхаг тэнэг хийгээд үгээгүү доорд ба үхээнц дорой болон төрөх хийгээд бас доргошлосоор гурван муу заяанааж унаад элдэв зүйлийн бэрх зовлонгуудыг амсахуйд хүрнэ” гэжээ. Бас “Муу нүглийн ач үр барагддаас... сайн үйлсийн шалтгаанаар... сэцэн мэргэн хийгээд баян эрхэм ба хүчин төгөлдөр болон төрөх хийгээд басхүү давшсаар мөнхүү тэнгэр хүний дээд жаргалант оронд төрөх болно”. “Энэ нь арга билгийн сайн муу үйлийн үр хариулан ээлжилж мандан буурахын өөрөө болсон ёсон буюу” гэжээ.

Бурхны шашны сургааль ёсоор буяныг арвитгах үүднээс элдвээр өглөг өгөх, өргөл өргөх, өнчин бэлбэсэнийг тэтгэх, өтгөс хөгшдийг асрах гэх мэт сургаалыг зүйл бүрээр ангилан сургасаны дээр шуналын сэтгэл, харам сэтгэл гаргахыг ихэд цээрлэхийг сургасан нь нэг бус юм. Тэрбээр “...Өтгөс хүнийг хүндлэх ба өнчин бэлбэсэнийг өршөөх, гачигдсан, маш мухардсанд туслах ба үгээгүү гуйланчинд өглөг өгөх”, “харамч хүнийг болбоос өглөг өгөхийг сурга”, “...маш гашуун зовлон тохиолдсон, маш гачигдсан, маш мухардсан амьтны тулд эрдэм мэргэн төгөлдөр өршөөл журамт сайнд баясагч эрдэмтэн сайд нар энэ мэтэд ялангуяа асрахуй нигүүлсэхүй сэтгэл үүсгэж, мэргэн аргын үүднээс чадах чинээгээр өөрийн үйл мэт тус хийж тэтгэх болбоос зохино. Ер нь аливаа гашуун зовлонтой ба гачигдсан мухардсанд тус хийх, тэтгэхүйд эх нь хөвгүүнээ энэрч өршөөх мэт үйлдэх нь чухал гэх мэтээр сургасан буй.

Дандаа чинсангийн энэ зохиолд “Журам бусын ашгийг тэвчих хорин есдүгээр бүлэг” гэгч тусгай бүлэг бий. Энэ бүлэгт тэрээр ёс суртахууны хэм хэмжээг зөрчиж ашиг олохыг зориуд шүүмжлэн цээрлэхийг сануулан сургаж тусгайлан өгүүлжээ. Түүний бичсэн нь: “Эд агуурс гэгч үнэхээр хүний амьдрах ёсонд амин зуухаас эл зүйлийн хэрэгсэлд хүртэл эрхэм доорд, баян үгээгүүг ялгахгүй нэгэн өдөр ч болон эдгүй болбоос үл болно... Аливаа хүн сайн муу болох хийгээд мандах буурах тухай нь бүрнээ аж төрөх хийгээд тус хэргийг хичээж чадах үл чадах хоёрт холбогдсон тулд

аливаа хүн хэрвээ холыг бодож цагийг нээж хичээн чармайх болбоос бардаагаар амьдарваас болох бөгөөтөл эрхбиш журам бусын ашгийг ховдоглож юу хийнэ” гэжээ. Өөрөөр хэлбэл аливаа хүн сайн муу аж төрөх нь гол аж ахуй, туслах салбар мэтийг эрхлэн чадах эс чадахаас л хамаарна. Тиймээс аливаа хүн урьдчилан төлөвлөж хичээн чармайж гэмээ нь аж төрөх боломжтой зүйл учраас ёс бус ашиг хөөцөлдөж дэмий ховдоглох хэрэггүй юм гэжээ. Цааш нь “үнэн юмны дотор худал хуурмагийг холих, огт үнэн бус атал дүрс нь адил өөр юмаар орлох, амуу будааны дотор элс холих, бага жин, пүү зарах, дутуу тооны мөнгө зоос талбиж хөлс үржүүлэх, хожиж холдуулах, бусдын юмыг дарах, булаах, хулгайлах, дээрэмдэх, шунах тэргүүтнийг үйлдвээс хэдийгээр нэгэн цагийн завшаан мэт боловч дагалдаагаар зовлон хүрч ирээд бие нь зовж улмаар мөхөж сөнөхөд хүрнэ” гэж сургажээ.

“... Эрт ба өдгөөгийн ховдог авилгач ардын эцэс хийгээд түүний хойч үеийнхнийг шинжилвээс сайн болсон нь нэгээхэн ч үгүй... гурван муу заяанд унаад зүйл зүйлийн зовлон эдэлсэн нь маш тодорхой. Тиймийн тул энэ бие хийгээд хойч үр ач нараа баахан хайрлаж бодогч ард журам бусын ашгийг тэвчихийг сургахын хамт хувраг тойн хүмүүс ашиг завшааныг эрж сахил санваараа гэж хөлсний хөдөлмөр эрхлэж буйг илт шүүмжлэн “цаасаар хайчлаж хийсэн цэцэг үр боловсрохгүйн адил ийм гэлэн тойд нь шашныг мандуулах үргүй” гэж шүүмжилсэн бий. Тэд “ямагт нэр зэрэг хийгээд олз ашгийг тэмцэж, зарим нь хар хүний гэрт хонь мал адгуулах ба эс бөгөөс гэрийн зардас болж тойдын ёсыг гутаан явах” гэж бичжээ. Энэ байдал нь То вангийн сургаал дахь үг өгүүлбэртэй яв цав нийлэлцэхийн дээр засаг ноён Цэрэнсантув ч бас ийм дүртэй хувраг олширсоньг шүүмжилсэн бий. Энэ нь тухайн цагийн монголын лам хувраг нэрт ардын үнэн төрх болсон байв.

Гэхдээ тэрээр басхүү баян үгээгүү болох нь зөвхөн үйлийн үрээс төдий бус өөрийн хичээл зүтгэлээс болохыг үгүйсгэсэнгүй. “Хэн нь үгүйрч амуй хэмээсэн нь, энэ нь... аж төрөх ёсыг үл хичээн осолдож, аж ахуй алдагдаж, эд агуурс хомс болоод гачигдах мухардахдаа муу нүгэлт үйлсийг эрхлэж зоволдох үр боловсрох” тул “жаргах, амрахыг үл эрэн, зовох зүдхээс үл халган цагийг дагаж хичээвээс зохино” гэжээ. Улмаар аж төрөхийн ёсыг хичээх нь, энэ урьд эд агуурс гарах үүр хөрөнгийг хүндэтгэж, тус хэргийг хичээх дотор буй амуй. Үүр хөрөнгө хэмээгч язгуураас уламжлан ирсэн тариа ба мал тэжээвэр мөн болой.

Тус хэрэг хэмээгч худалдаа арилжаа хийх, үйлч дархан хийгээд аливаа зүйлийн хүчин гаргагч тэргүүтэн мөн буюу. Үүнээс идэх өмсөх хийгээд жич аливаа хүний амьдрах ёсныг осолдвоос эд таваар чухаг болоод хэрэгсэл үл хүрэлцэх тул, үүнээс даруй гачигдаж мухардахад хүрнэ. ... Аль нэгэн зүйлд болбоос эдгүй бол үл болно хэмээх ч байтугай, үүнээс эдийн хэрэглэл үл хүрэлцэх учирт басхүү өдөр бүр сэтгэл санаа амаргүй зовнин гутаж мухардахдаа арга барагдаад хүчирхэг ард болбоос муугаар явж цаазыг халдаж ял янга болно. Буурай болбоос эгнэгт зовон зүдэж, өлбөрч дааран гачигдаж мухардсаар гуу сувагт унахуйд хүрнэ. Ийм бэрхийн тул эс хичээвээс болно уу” хэмээжээ. Дандаа чинсан, энд аж ахуйн гол эх сурвалж “үүр хөрөнгө” нь тариалан, мал аж ахуй харин туслах салбар нь “худалдаа арилжаа, үйлч, дархан, аливаа зүйлийн хүчин гаргах /буюу биеийн хөдөлмөр эрхлэх/ тэргүүтэн гэж тухайн үеийнхээ аж байдлыг бодитойгоор тусгаж байсны дээр “эд үл хүрэлцэх нь өдөр бүр сэтгэл санаа амаргүй зовнин гутах гэсэн нь ахуйн гачигдлаас болж сэтгэл санаа гутаж” сэтгэхүй

өөрчлөгдөнө гэж хэлсэн байна. Ингэснээрээ тэрээр сэтгэлээс үүдэж ахуй өөрчлөгдөнө гэж үздэг шашны идеалист үзлээс ангид буй нь харагдах юм. Бурхны шашны зарим номлогчид өнөө ч гэсэн баян ядуугийн ойлголт нь сэтгэхүйн зүйл гэдэг. Аливаа хүн өөрийгөө ядуу бус гэж бодвол ядуу бус болно гэж номлодог билээ. Харин Дандаа бол аливаа хүний амьдрах ёсныг осолдвоос үгүйрч эдийг гачаалд орно гэдгийг тов тодорхой өгүүлжээ.

Тэрээр аливааг хэмнэх, гамнах, зохистой хэрэглэхийг мөнөөхөн бусад зохиогчдын нэгэн адилаар хичээнгүйлэн сургажээ. “Дэмий оо энгэсэг түрхэж, хээтэй сайхан хувцас өмсөөд алт мөнгөн эрдэнийн заслага зүүж, хээнцэрлэн засаж, хэрэггүй газарт эд таваарыг сүйтгэж, төрөлхийн буянаа бууруулж, нүглийн тулмыг үүтгэх, хурьцахын зууч ирэхүйд хүрүүлэгтэн”, “Зоос наадах” хийгээд /мөрийтэй тоглох гэсэн үг Д.Т/ элдэв зүйлийн наадмыг бүү наадагтун. Аж төрөх саатахаас гадна нэр цаг гутагдаж, эд таваарыг бүрэлгэнэ”, “...хичээнгүйгээр биеэ сахиж, аж төрөхийг хичээх ба эд таваарыг хайрлаж арвилах хураахыг эрхлэх ба архи дарс уухыг цээрлэх” гэх мэтээр удаа дараа бичсэн буй.

Чимэдийн Дэмчигдорж буюу Дандаа чинсан гэгч бичгийн сэхээтний энэ сургаалыг ерөнхийлөн дүгнэвээс бурхны шашны үзлийг номлохын дээр ардач, зөвсүгч үзэл, аж төрөх арвич хямгач ёс, хөдөлмөрч хичээнгүй зүтгэл, дэг журамтай амьдралыг номлосон бөгөөд төрөлх ардынхаа аж төрөх ёсыг дэлхийн бусад олон улс түмнийхтэй жишиж хөгжлийн өөдрөг замд хөтлөхийг чармайсан гэж үзэж болно.

Ч.Бат-Очир “Мандах нарны туяа”

Дандаа чинсантай нэгэн үед аж төрж сургаалын өөр нэгэн зохиол туурвигч нь “бичээч” гэж алдаршсан Чулууны Бат-Очир болно.

Тэрээр Хан Хэнтий уулын аймгийн Өндөрхаан уулын хошууны Хэрээ хөхөл сумын нэгдүгээр багийн харьяат гэж өөрийн намтартаа бичсэн буй. Энэ нь одоогийн Хэнтийн аймгийн Баян мөнх сумын нутаг болно. Ч.Бат-Очир нь 1874 онд төрсөн бөгөөд Богд Хаант улсын үед Шашин төрд туслах яам, Хууль цаазны бичиг зохиох газар зэрэгт бичгийн түшмэл, Ардын хувьсгалаас хойш Гадаад яаманд туслах түшмэл, Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн зэрэг ажил хийж явсан манж, хятад, төвд хэл бичиг мэддэг монгол бичгээр туурвил зохиолоо бичдэг хүн байжээ. Ч.Бат-Очир нь Д.Нацагдоржийн хамт манай улсын анхдугаар үндсэн хуулийн 1924 онд батлагдсан уг эхийг сийрүүлэн бичиж үлдээсэн гэдэг. Тэр 1926 онд “Мандах нарны туяа” нэрт сургаалын зохиолоо бичжээ. Бид энэ зохиолын 1992 онд кирилл үсгээр шинээр хэвлэгдсэн эхийг баримтлан бяцхан дэлгэрүүлж үзсүгэй.

Ч.Бат-Очирын “Мандах нарны туяа” хэмээх сургаал нь 52 жижиг гарчиг бүхүй бүлэгтэйгээс 13 нь шууд эдийн засгийн агуулгатай бусад нь бидний авч үзэх сэдэвт дам холбогдох юм. Тухайлбал, санхүү гэсэн 16 дугаар бүлгээс эхлэн заримдаа дараалан, заримдаа бүлэг алгасан эдийн засгийн агуулга бүхүй гарчиг харагдах болно. Бат-Очир бичээч гэгч бичгийн сэхээтэнд тооцогдож байсан бөгөөд энэ зохиолыг бичих болсон тухайгаа оршил хэсэгт нь бичихдээ “... Одоо хараахан гэгээн засгийг байгуулж аливаа эрдмийг үүсгэн сурч бүхүй цаг бөгөөд сая сурах хөвгүүд дүү нар бичгийн эрдэм, сургууль соёлыг урьтал болговол зохихын тулд өөрийн мунхаг хүдхийг бодохгүй эртний эрдэмтдийн зохиосон бага сургууль бичиг, ертөнцийг ухуулах чухал үгний

бичиг, зургаан хэргийн цээрлэл үгний бичиг, богдын сургаалыг сэнхрүүлэн бадруулсан бичиг, хааны бичсэн дөрвөн бичиг, судар шастир, толь бичиг ба жич аль хэрэгтэй бичиг, дүрмүүдээс чухал хэрэглэгдэх үгсийг хураамжлан түүвэрлэн бичиж нэгэн дэвтэр тавин хоёр зүйл болгон дүү нар, хөвгүүдийг сургах “Мандах нарны туяа” хэмээн нэрийдэв гэжээ.

Энд Бат-Очир бичээч бидний үед уламжлан ирээгүй цөөн бус сургаалын нэрийг дурдаж, ашиглаж ишлэсэнээ өгүүлсэнийг анзаарч болно. Тиймээс “Мандах нарны туяа” сургаал нь монголын сургаалын зохиолын хуучин уламжлалтай, холын үндэстэй бүтээл гэж үзэж болно. Ер нь манай өвөг дээдэс анхлан бичиг эрдэмд сурч буй багачуулын ёс суртахууны хүмүүжилд гойд санаа тавьж тэдэнд зориуд “ёс суртахууны сурах бичиг” болгосон ном хэрэглэгдэхүүнийг анхлан уншуулж нүдлүүлэн эрдэм номд шамдах, аж төрөхөд сургах, ахас ихсийг хүндэтгэх, аав ээжээ өргөх, нялхас балчрыг өсгөх, ханийн элбэрэл журмыг хүндэтгэх гэх мэтэд оюуныг нь нээгдүүлэн хүмүүжүүлэхэд анхаарч ирсэн байна. Тиймээс сургаалын зохиолын бие даасан төрөл зүйл бий болж цэгцрэн төлөвшсөн гэж үзэж болно.

Бат-Очир “Эдийг арвилах” нэрт бүлэгтээ “Хүн эд хэрэглэхүүнийг нэгэн өдөр хэмээвч үгүй болгож болгохгүй болой. Аливаа эд таваар хэмээгчийг эс хэмнэвэл элсэнд ус асгах лугаа адил даруй ширгэхийн тулд арвилахыг эс хичээвээс үл болмуй. Эртнээс нааш иргэний хэв хууль цөм арвилах хэмнэхийг эрхэм болгожээ” гэж мөнөөхөн “Богдын сургаалыг сэнхрүүлэн бадруулсан бичгийн” санааг давтжээ. Арвилах гамнах, хэмнэх тухай үгс түүний зохиолын олон бүлэгт давтагдах ажээ. Харин Дандаа чинсан. То ван зэргээс ялгаатай нь Бат-Очир ядуурлын шалтгааныг “үйлийн үр, муу заяа, муу зовлонт болгон төрүүлдэг” гэж хэлсэнгүй шууд л “өөрийн муу явдалд хамаарах зүйл” гэжээ.

Тэрээр бичсэн нь “Ертөнцийн хүний үгээгүү ядуу болох учир болбоос өөрийн өөдгүй муу явдалд хамаарах нь бас буй амуй. Эс бөгөөс архи ууж хөрөнгийг сүйтгэх эс бөгөөс зоос наадаж гэрийг цуцруулах / гэр бүл салах гэсэн үг.Д.Т. / эс бөгөөс хулгай худал хийж өрхийг чирэгдүүлэх, эс бөгөөс эмс охидод явалдаж эд барааг бүрэлгэх эс бөгөөс өвчин эмгэгт үгүйрэх нь адилгүй болой” гэжээ. Энд урьд насны үйлийн үрээр юм буян заяа доордсоноор ядуурдаг гэсэн шашны сургаал алга байна.

Харин “нэгэнтээ үгүйрвэл биеийг хайрлахгүй албан ба ах дүүд туслаж сайшаалыг олбол амь тэжээх, амь улжихыг бардаагаар хүрэлцүүлбэл болмуй. Эцэг эхийг тэжээж, амраг саданг тэтгэвэл болмуй. Ямагт биеийн амрыг эрвэл гуйранчлан өлбөрч үхэхийг хэлтэрвээс болохгүй болой” гэжээ. Өөрөөр хэлбэл ядуурлын шалтгаан нь өөрийн муу явдал гэхийн дээр түүнээс гэтлэх арга зам нь биеийн амрыг үл харан хөдөлмөрлөх явдал болно.

Шашны сургаалтан юм уу зарим ноёдын сургасан шиг “буян хураах, алба дээж өргөх” гэсэн үг Бат-Очирын сургаалд тааралдахгүй байна. Тэрчлэн “хүн төрөхүйд нэгэн адил эцэг эхээс төрмүй... гэрийн эзэн ба зарц хэмээн ялгавартай төрөх нь бус болой” гэжээ. Дандаа чинсангийн адилаар “Муу зовлонт болон төрөх” гэгч үзэл Бат-Очир бичээчид үгүй байна. Бат-Очир аливаа хүнийг “Гагцхүү явдлын сайн муугаар баян үгээгүү ялгагдмуй” гэжээ. Гэтэл То ван “Хоосорно гэгч эртний үйл” гэсэн байдаг. Бат-очир бол “Хүн болж төрөөд элбэг чинээлэг болсон учир нь өөрийн биеийн эрдэм чадлаар элбэг болсон, худалдаа арилжааг сайнаар гүйлгэж чинээтэй болсон, эцэг

өвгийн үлдээсэн баялаг хөрөнгийг залгамжилсан, бусдын ихээхэн хөрөнгийг хураан авсан зэргээр хүмүүжиж, дээдэд бол албыг залгамжлуулан, дордод бол өөрийнхүү амины тэжээлийг бэлтгэн хэвийг сахивал болмуй за” гэжээ. Түүний бичсэн нь “Заримууд нь хэтэрхий хүү үржүүлэн бусдыг мөлжих, төлөөнөө албыг залгамжлуулан хэмээх нэрээр бусдын хөрөнгийг хураах, эдэд эрэмшиж дордсыг дарлах, түшмэлд хахуулилж хилс гүжрээр бусдыг унагаах зэргээр зүй бусаар явагчид нь бас ч буй. Энэ мэт хүн хөрөнгөтэй явсанаас ядуу явбал олонд амар болмуй” гэж баялаг ихэрхэг ардын тулд бус олны тусын тулд санаа өгүүлсэн буй. Тэрээр ардач үзэлтэй ажээ.

Тэрбээр аливаа хүнийг гагцхүү хичээл хөдөлмөрөөр аж төрөхийг сургаж “Цэргийн хүн бол цаанадаж улсыг сахих, наанадаж мөнхүү өөрийн хэрэг буй болой. Явгалж мордох, харваж намнаж сурахыг чин сэтгэлээсээ хичээ. Давших байлдах, зогсох тэгшлэхүйг боловсруул. Хамгаалах халхлах цагдах, эргэцэх, бэхлэх сэргийлэхийг хичээ.

Бичгийн хүн бол биеэ сэрэмжлэн явдлаа засаж насыг өрсөж бичгийг сурагтун. Тариачин эр болбол, хавар тарьж намар хураа. Цагийг дагаж. хэмнэн арвилаж, үер, ганг эртхэнээс бэлд.

Үйлч дархан бол дөрвөн цагт нийлүүлж, зургаан хэрэглэлийг тэгшлэн хороонд сууж үйлсээ бүтээ. Бүү залхуурагтун.

Худалдааны хүн болбол буй. үгүйг нэвтрүүлэн, үнэтэй хямдыг тэнцүүл. Харилцан худалдаа нийлж, хэрээ дага. Худал зусрыг холдуулж тус тусыг хичээвээс бүгдээр элбэг дэлбэг болж гэгээн тэнэгэр, гэрэлт нарны дор цэнгэлдэн буяныг эдэлбээс болмуй” гэжээ.

Бат-Очирын зохиолд монголын сургаалын зохиолын дотроос анх удаа “Албан татвар, мөнгөний банк, хоршоо худалдаа” гэсэн цоо шинэ сэдэв орж ирсэн нь сайшаалтай боловч түүний энэ талаарх сургаал нь зөвлөгөө мэдээллийн чанартай нь дийлэнх бөгөөд онол, номлол, үзэл санааны хувьд өнгөцхөн ажээ.

Ерөөс Бат-Очирын төдийгүй нийт зохиогчдын сургаалууд нь эдийн засагчдад зориулсан сурах бичиг юм уу аж ахуйн ажилтан нарт зориулсан ном бүтээл биш эгэл ардад зориулсан ёс суртахууны зөвлөгөө сургаал маягтай байгааг онцлон анхаарвал зохино.

Бат-Очир сургаалынхаа “Албан татвар” гэсэн хэсэгт бичсэн нь: “Улс төрийн газар олон иргэний алба авцгаах ба олон ард нь улсад алба барих ба жич гааль түрээс хураах нь эрт ба эдүгэгийн нэвтэрхий журам бөгөөд хэрхэвч татаж аваад улсын хэрэглэхүүн орон сав барих засах, цэргийн цалин, түшмэлийн пүнлүүнээс дараалан ховор зудад бэлтгэн мөнхүү түмэн иргэнд түгээн өгч тэнхрүүлэхээс бус улсын эрх баригчид биедээ ашиглахыг бодсон нь бус болой. Иймийн тул албан татварт чавхуурхан мөчөөрхөж, хойшлуулан хийдүүлсний хойно цухалдуулан хөөхөд хүргүүлбэл улсын хэрэглэхүүнийг саатуулсан яланд унаж торгогдох, шийтгэгдэхүйн тулд үнэнч сэтгэлээр хугацааны дотор албыг баривал дээдэд цэрэг ба улсыг санах, дордод бие ба гэрийг санах саналыг илэрхийлсэнд болох буй заа” гэсэн буй.

”Хоршоо худалдаа” гэсэн сэдэвтээ “Улсын харилцан туслалцаа хоршоо худалдаа байгуулсан нь гадаад улсын ховдог шунахай худалдаачны мөлжих идэхээс ангижруулахыг хичээсэн зорилт” гээд “Алив түүхий эд юмыг гадаадын худалдаачинд өгөхийг зогсож, монголын харьяат хоршоо худалдааны газарт өгөхийг олноор

хичээвээс гадаадын мөлжигдлөөс хэлтэрэхийг мэдвэл болмуй. Иймийн тул олон түмэн ард нар учрыг ухаж, хоршоонд туслаж улсын дотор ашгийг багтаавал /үлдээвэл гэсэн үг/ засгийн бодлогод нийлэлцэж, хоршооны ажил улмаар сайжрах” гэжээ. Түүний бичсэн “Мөнгөний банк” гэсэн хэсэг нь мөн ийнхүү ухуулан таниулах зорилготой байна. Тэр үед манайд үндэсний мөнгөн тэмдэгт, үндэсний банк гэгч зүйлс анх бий болоод төдийлэн удаагүй байсны тул ингэж олон нийтэд зөвлөн ухуулах нь шаардлагатай бөгөөд чухал зүйл байсан хэрэг болой.

Бат-Очир өөрийнхөө сургаалд “Адгуус малыг адгуулах”, “Тариаланг эрхлэх”, “Хулгуух булаах” гэх мэт аж ахуйн хийгээд эд материалын дахин хувиарилалтын холбогдолтой сэдвийг оруулсан байх боловч гойд содон санаа сэдэл багатай байна.

“Мандах нарны туяа” сургаал нь ерөнхийдөө иргэний ёс суртахууны шинжтэй боловч шашны нөлөөнөөс огт ангид бус. Түүний дотор хааяа буян, нүгэлийн тухай ойлголт цухалзаж байдаг. Мөн энэ сургаалд эрэгтэй эмэгтэй хүн адилхан тэгш, гэрийн зарц, өрхийн эзэн гэгч нь нэгэн үеийн хэрэг, аливаа хүн угаас ядуу зарц болж төрөөгүй, хожим нь зарц нь тэргүүлэгч, эзэн нь түүний зарц болж ч болно гэх мэтээр ангич бус байр сууринаас сургасан байдаг. Дээр үеийн сургаалын зохиолуудад дээдэс, дордос гэсэн үг нь шууд угсаа гарал, ангийн ялгаварыг тусгасан шинжтэй байдаг бол Бат-Очир бичээч энэ нэр томъёог гагцхүү хөрөнгө чинээний байдалтай холбож үзсэн мэт харагддаг юм.

Бидний санахад “Мандах нарны туяа” хэмээгч сургаал нь ёс суртахууны сурах бичиг байдлаар эртний уламжлалаар зохиосон хамгийн суулчийн бүтээл болов уу. Түүнээс хойш иргэний сургаалын ийм хүүрнэл зохиол гарсангүй харин аж ахуйгаа хөтлөх эрхлэх зөвлөгөө сургаалын зохиол гарч байжээ.

Тарав Бандид “Ард түмний ариун ёсон”

Ардын хувьсгалын анхны жилүүдэд зохиогдсон өөр нэгэн сургаалын бэсрэгхэн зохиол бол Тарав бандид хувилгаан Агваанлуvsсанчойжирдондовын “Ард түмний ариун ёсон оршивой” гэдэг бүтээл юм.

Түүнийг зохиогч Агваанлуvsсанчойжирдондов буюу Тарав бандид гэгч нь өнөөгийн Архангай, Хөвсгөл аймгийн зааг нутаг, Идэр, Чулуут голын сав тэр үеийнхээ Сайн ноён хан аймгийн Хөндлөн мэргэн засаг Мөнх-Очирын хошууны Рашаант сумын / Өнөөгийн Хөвсгөл аймгийн Рашаант сум/ харьяат малчин Насангийн гэрт 1870 онд төрсөн байна. Тэрээр бага наснаасаа Их хүрээнд шавиан номтой сайн багшид шавь орж бурхны гүн ухааны номд нэвтэрхий суралцан төвд хэлээр бүтээл туурвих болж 36 насандаа гавжийн дамжаа, 49 насандаа аграмбын дамжаа барьж, Богд хаант Монгол улсад заларсан XIII Далай ламд бараа болж дагалдан ирсэн төвдийн эрдэмтэн лам нартай ном хаялцаж Бандид цолоо хамгаалсан ажээ. Бандид гэдэг нь таван ухаанд нэвтэрсэн эрдэмтэн хүнд олгодог цол гэдэг. Тэрээр 1921 оны Ардын хувьсгалыг талархан угтаж өөрийн эрдэм чадлыг шинжлэх ухааны үйлсэд зориулан Судар бичгийн хүрээлэнд манай ахмад үеийн эрдэмтэн судлаачидтай мөр зэрэгцэн ажиллаж байжээ. Энд ажиллаж байх үедээ бусад судлаачдын хамт Франц улсад очиж монголч эрдэмтэн Пелльод шавь орж суралцаж байсан байна. Тэрээр “Ард түмний ариун ёсон оршивой” гэдэг сургаалын зохиолоо 1922 онд 52 настайдаа бичсэн ажээ. Түүний энэ зохиол тэр үедээ төвд, монгол бичгээр нэг бус нийтлэгдсэний дээр 1991 онд монгол кирилл үсгээр

хоёр ч удаа хэвлэгдсэн юм. Бид аграмба лам Нанзадын Дашзэвэгийн монгол үсгээр буулган Хөх судар хэвлэлийн хоршоо эрхлэн хэвлэсэн эхийг баримтлав.

“Ард түмний ариун ёсон оршивой” хэмээх зохиол нь харьцангуй жижиг бөгөөд дотроо дугааргүй, хуучин монголын бичгийн уламжлалаар шинэ сэдэв эхлэхдээ мөр тэтгэж эхэлсэн арав шахам зүйлээс бүрдэл болно. Үүний нэлээд нь бурхны шашны сургаалын агуулгатай боловч иргэний, аж ахуйн чанартай сургаал цөөн боловч туссан байна.

Тарав бандид мөнөөхөн “Богдын сургаалыг сэнхрүүлэн бадруулсан бичгийг” өөрийн сургаалдаа дурдсан буй. Түүний бичсэн нь: “...Богдын сургаалыг сэнхрүүлэн бадруулсан бичиг, хааны сургасан чухал үгийн дэвтэр, жич гадаад улсын мэргэдийн ертөнцийн орших зүйлүүд хийгээд улс төрийн ёсыг өгүүлсэн бичгүүд их бага сургуулийн бичгүүдийг сурч ухаан нээгдэн эрдэмтэн болбоос ихэмсэг ноёд ч түүний боол дор болох” гэжээ.

Тэрээр өөрийн орны онцлог байдлыг харгалзан “манай халх монголчууд хөрөнгө хомс, хүчин буурай эрдэм суралцах нь нэвтэрхий хэрэгтэй учрыг дахин дахин хянан бодож олоод эрдэм сурахад эд хөрөнгө тэгшхэн арвижих хэрэгтэй учрыг бас санан олж мэдээд олон бүгдээр юуны урьд урьдал болгон албан татварыг хөнгөлөн /онцлов Д.Т/ аль сайхан арга бодлогоор хөрөнгийг зузаатган үйлдвэл сайн” гэжээ.

Хүн ам цөөнтэй, хөрөнгө багатай улсын хувьд эрдэм мэдлэгийн хүчээр улс орныг хөгжүүлэх нь хамгаас чухал гэдэг санаа Тарав бандидын сургаалд шингэсэн байх бөгөөд үүний тулд юуны өмнө албан татварыг хөнгөлөх явдлыг анхааруулсан байна. Албан татварыг хөнгөтгөх гэдэг нь Ардын засгаас өмнөх үеийн албан татвар өндөр санагдаж шинэ засгаас түүнийг бууруулах нь зүйтэй гэсэн санаа хэлсэн хэрэг юм. Тэрээр цааш бичихдээ “Харанхуй олон ардуудад эрдмийн зүйлийг эрхэм болгон дэлгэрүүлэх, эдийн засаг ба улсын хөрөнгийг шинэ суртлын ёсоор зузаатгах нь эрхэм” гэсэн буй /онцлов Д.Т/. Улс орны нийт эдийн засаг, улсын хөрөнгийг шинэ үзэл баримтлалын ёсоор бэхжүүлэх зузаатгахыг Тарав бандид чухалд үзэж Ардын хувьсгал ялаад ганц жил болж ахуйд бичсэн энэ бүтээлдээ дурдсан нь эдийн засаг, төрийн бодлогоос ангид хувраг хүний хувьд туйлын сайшаалтай зүйл болно. Түүнээс өмнөх үеийн зохиогчид бол “дээшийн алба барих, буян үйлдэх, өргөл өргөх” гэх мэтийг гол болгон сургадаг байсан бол тэрбээр улсын санг зузаатгах санал тавьжээ. Тэр “эрдэм сурахад эд хөрөнгө тэгшхэн арвижих хэрэгтэй” буюу боловсролд хөрөнгө зарах ёстой учраас албан татварыг хөнгөтгөө гэж бичиж байжээ. Тэрээр шинэ төр засгийг туйлаас сайшааж хүлээн авсан байна.. “Сүр хүчин ихтэй ноёд лам нар өөрийн хүсэл зоргоор завсар хоорондоо эсэргүүцэлдэн доош иргэдийг хог шороо мэт хөнөөн үргэлж боолчлох... барагдашгүй зовлон эдүгээ гүйцсэн” гэж тэрээр шинэ цагийг дүгнэн бичээд “мунхаг ядуусыг эрдмээр сэнхрүүлэн, өршөөлөөр тэнхрүүлж амар тайвныг адилхан хуваахад өөр өөрийн хэр чинээгээр зүтгэх цаг магад болжээ” хэмээн олон нийтийг уриалан сургасан байдаг. Тэрээр цааш нь “Аливаа улс төрийг тэтгэгч олон ардыг эрхэм, доорд хэмээн ялгаварлахгүй цөм нэгэн адил шудрагыг гол болгон үзэж, ард түмний хөрөнгө амьдралыг хэмнэхийг урьдал болгон аливаа гарлагатай зарлагыг хасаж, олны зовлон зүдгүүрийг тэгшлэх ба ард түмний асрах нигүүлсэхийг гол болгосон... түшмэл нь улс төрд онц их эрдэнэ” гэж бичсэн буй.

Тарав бандидын “Ард түмний ариун ёсон оршивай” хэмээх сургаал нь бүхэлдээ хэдүй бурхны шашны агуулгатай нь харагдах боловч иргэний ээвэргүү өөдрөг, улс

орнод бий болсон улс төрийн шинэ нөхцөл байдлыг зөв тусгасан олныг эрдэм сурлага, нийтийн тусад уриалан дуудсан шинжтэй бүтээл юм. Түүний сургаалын дотор ёс суртахууны аж ахуйн, сүсэг шүтлэгийн олон санаа агуулагдах боловч хүнлэг зөвэргүү хандлага, арвич хямгач ёс, хөдөлмөрч шударга байдлыг номлосон нь илэрхий байдаг. Түүний сургаалд өгүүлсэн зарим чухал санаа сэдэл өнөө ч ач холбогдлоо алдаагүйг санавал зохино.

Хоёр. Сургаалын шүлгүүдийг хөндөх нь:

Монголын сургаалын зохиолуудыг эмхлэн судлах ажлыг сэдэн үйлдсэний гавьяа Ц.Дамдинсүрэн гуайд ногдох буй заа. Тэрээр “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршивай” бүтээлдээ нийт арав шахам сургаалын зохиолын олон эхийг нягтлан тулгаж сийрүүлэн хэвлүүлжээ. Энд Н.Ишданзанважирын “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал” Тобагийн гэгээний “Тоть шувууны сургаал”, Равжаа хутагтын “Сэтгэлийг амраагч” зэргээс гадна зохиогч нь тодорхойгүй “Нэг үсгийн эрдэм”, “Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг” зэрэг уламжлалт ёс суртахууны шилдэг өвийг тусгасан яруу сайхан зохиолуудыг оруулсан байна. Бид энд тэдгээрээс заримыг тусгайлан хөндөх оролдлого хийв.

Энд нэгэн зүйлийг тэмдэглэхэд Тоба гэгээний зохиол хэмээн Ц.Дамдинсүрэн “Зуун билиг”-гээ хэвлүүлсэн байдаг “Тоть шувууны сургаал”-ын өөр нэгэн хувилбарыг П.Хорлоо То вангийн сургаал хэмээн нийтлүүлсэн/П.Хорлоо.1998-116/ байдаг. Энэ хоёр сургаал хэдүй нэг нь хувраг хүн зохиосон гэгдэх, нөгөө нь То ван буюу ноён хүн зохиосон гэгдэх боловч хоёул нэгэн зохиолын хоёр хувилбар гарцаагүй мөн бөгөөд агуулгыг үзвээс XVIII-XIX дүгээр зууны үед зохиогдсон болов уу гэж үзүүштэй юм.

Сургаалын дотор:

*“Ашдын ноёд эзнээ зохистой хүндлэн
Айлтгасан зарлигийг ёсоор хүндэтгэн
Алба татвараа саадгүй төлөөд”*

гэх мэт үгс буйг ажваас хаадын эзэмдлийн үе өнгөрч, ноёдын эрх мэдэл батжиж, “губчир губчих” аргаар хааны алба залгуулах бус харин элдэв алба татвар оноолт цэгцэрсэн үеийн сургаал болов уу гэхээр байдаг.

“Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг”

Дөрөв дөрвөн мөрт шүлгээр багцлан нэгэн утгыг илэрхийлсэн 29 бадаг бүгд 116 мөр сургаалын үгс бүхий шүлэглэсэн зохиол юм. Зохиогч он цаг тодорхой бус боловч Ц.Дамдинсүрэн гуай, “... Зуун билиг”-гээ оруулахдаа “XIX зууны үе буюу түүнээс хойших үеийн зохиол гэж таамаглаж нь болмуй”/Ц.Д. 1959 -476/ гэжээ.

Эхний найман мөр шүлэг оршил болгосон байдалтай юм. Үүнд:

*“Эртнээс эс үзэж сонссоны эрхээр
Элдэв хувилгасан шүлгийг байтугай
Энгийн үгийн төдийг эвлүүлж
Эс чадагчид туслахын тул
Эгнэгт нэгэн хэдэн үгийг бичсүгэй
Тэдгээрийн ухаанд орохын амрыг бодож*

Тэмдэгтэйяа дөрөв дөрвөн үгсээр ялгаж таниулах нь”
гэж эхлээд цаашид, “дөрвөн мөнх”, “дөрвөн хэврэг”, “дөрвөн сайн”, Ажиглахад төгсгөлөөсөө дутуу байж болох мэт санагддаг юм.

“Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг” бүхэлдээ бурхны шашны гол сургаалд суурилсан гэж үзэж болно. Эхлэхдээ л “Бодь хутагийг олох буян хураах” гэсэн үгсээр эхлэх бөгөөд цаашид ч “энэ нас хэврэг”, “нирван мөнх” гэх мэтээр номлон сургасан нь олонтаа байна. Гэхдээ цэвэр шашны сургаал биш, ахуйн, иргэний эгэл ёс суртлыг номлон сургасан нь дийлэнх юм. Энэ сургаалын дотор эд хөрөнгө, зоос мөнгө ажил хөдөлмөр, шунал, өглөг зэрэг эдийн засгийн холбогдолтой мөр цөөн бус ..

Бид уул шүлгийн дотроос өөрсдийн хөндөж буй сэдвийн дагуу зарим мөр бадгийг түүвэрлэн үзье. Үүнд:

“Эцэс дор барагдахын тул хураасан бүхэн хэврэг”.

“Хэн дор эд буй бөгөөс түүн дор харам буй”.

“Үргэлж шунал тачаангуй лугаа нийлэгчдийн авьяас муу

Өчүүхэн олзонд баясагчдын хишиг муу”.

“Хээмсэг гоёлыг эдлэгчдийн эд таавар буурах”.

“Ханан цадагч сэтгэлтэн дор эд таваар олон”.

“Хомголзох шунахай сэтгэлтэн олз ашиг цөөн”.

“Ховдоглох санаа ихэдвээс олз ашиг цөөн”.

“Олз хүндлэл дор дурлагчдын баясах нь хялбар”.

“Цөөн хураасанаа хайргүй эдлүүлэх эцэг эхийн өршөөл үнэн”.

“Олз гарз үл бодогчдын эдлэл амар”.

“Байх эд таваараар цагийн жаргал авах”.

“Хонжих, ашиглах, олздох нь гүйцэшгүй тул тэвчвээс тустай”

“Хэмжээтэй хэдэн малтай бөгөөд гэнэт баярхах буруу”

“Бусдын эд таваар дор шунаваас буян хишиг тархах /тарж алга болох/” гэжээ.

Энд бүгд 15 мөр сургаал шүлэг иш татсанаас үзвэл үндсэндээ бурхны шашны шуналын сэтгэлийг тэвчих, үл харамлах, хонжих ашиглах, ховдоглох сэтгэлийг шүүмжлэх сургаал номлолд үндэслэсэн байх нь тодорхой харагдана. Шунахай сэтгэлтэй байвал “эд мал, олз ашиг цөөн” бас “гүйцэгдэшгүй” тул “ханан цадах сэтгэлтэнд эд таваар олон” гэж сургажээ.

“Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг”-ийн доторх эдийн засгийн агуулга бүхий мөрүүдийг шүүрдэж үзсэний эцэст дүгнэвээс олз ашгийн төлөө хөөцөлдөх, шунахай сэтгэл өвөрлөх, ховдоглохыг тэвчихийг номлосон зохиол гэж үзэж болох байна. Энэ зохиол бүхэлдээ монгол хүний төрөлх сэтгэхүйд бүрэлдсэн ертөнцийг үзэх үзэл, бурхны шашны сургаалын хослолоор зохиогдсон шинжтэй бөгөөд хойч үеийнхэнд үе улиран сургаал болсоор байх ёс суртахууны сурах бичиг гэж үзүүштэй.

Ишданзанванжил “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал”

XIX зууны эцэс XX зууны эхэн үед бүтээн туурвиж агсан шашны нэгэн томоохон зүтгэлтэн, сургаалын шүлгийн зохиолч бол “Гүнгийн зуугийн гэгээн” гэж алдаршсан Н.Ишданзанванжил /1854-1907/ юм.

Тэрээр монгол төвд хоёр хэлээр зохиол туурвиж байсан бололтой. Тэрээр “Галын шастир зохиолоо төвд хэлээр, “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал”-ыг монгол хэлээр бичсэн байна. “Галын шастир”-ыг нь төвдөч Ч.Алтангэрэл монголчлон кирилл монгол үсгээр хэвлүүлсэн бий /14 - 89/. Ишданзанванжилын зохиолоос нэлээд дэлгэрсэн нь “Гүнгийн зуугийн гэгээний Алтан сургаал” болно. Энэ зохиол манай оронд 1928 оноос эхлэн нэг бус удаа хэвлэгдсэн юм. Зохиогч Ишданзанванжил нь зөвхөн уран зохиолч шүлэгч биш тухайн цагийн уламжлал ёсоор таван ухаанд мэрэгшиж , эм барьж жорын ном бичсэн оточ байжээ.. Түүний бичсэн уламжлалт анагаах ухааны “Шүрэн унжлага”, “Сувдан унжлага”, “Эрдэнийн унжлага” гэдэг цуврал гурван дэвтэр бидэнд хүрч ирсэнээс зармыг нь кирилл монгол үсгээр хэвлэсэн ч бий.

Ишданзанванжил нь өнөөгийн Өвөрмонголын нутагт Цахарын хөвөөт цагаан хошууны амбан Намжилдоржийн гэрт 1854 онд төржээ. Долоон настайдаа Ордос нутагт Гүнгийн зуу сүмийн шаврун /Шаврун гэх нь бараа болж дэргэд байгч гэсэн утгатай төвд үг гэх бөгөөд шаврун хувилгаан гэх нь ихэсийн дэргэд шадарлах хувилгаан гэсэн үг болно/ гэдэг мяндагтай лам болон залагдаж 15 нас хүртлээ монгол төвд хэл бичигт суралцжээ. Ордост хотонгийн үймээн самуун гарч түүний сүм хийдийг шатаасан тул нутагтаа ирж хэдэн жил болоод хориод насандаа Гүмбүм /одоо манайхан Гүмбэн гэж хэлээд байгаа нь аялгуугаа дагаж буруу нэрлэж буй бололтой. Уг хийд нь төвдийн Амдо нутаг бөгөөд Богд Зонхова Лувсандагва гэгээний төрсөн газар болно./ хийдэд очиж шашны гүн ухаан, анагаах ухаанд ултай суралцжээ. Ишданзанванжил тэндээс Ордос нутагт ирж өөрийн хийдээ сэргээж суусан гэх бөгөөд улмаар Ар Өвөр монголын нутгаар явж Халхад нэг бус жил суусан байна. 1903 онд Ар монголын Их хүрээнд сууж байхад нь шавь нар нь хойноос нь ирж залж аваачсан байна.

“Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал” зохиол нь 5 бүлэг 89 бадаг бус бүр нь 4 мөрт шүлэг бөгөөд бүгд 356 мөр юм. Уул зохиолыг Ордос хошууны Засаг ноён Эрхэмбилэг гэгчийг нэр заан шүүмжилж бичсэн гэх үгс ч байдаг. Ишданзанванжил энэ зохиолоо түүнд илгээснийг үзээд хилэгнэж нухчиж хаясан гэдэг. Мөн 1990 оны орчим манай зарим хэвлэлд “Гүнгийн зуугийн гэгээний алтан сургаал”-ыг Ишданзанванжил зохиосон бус харин Баргын Жодов амбан зохиосон гэж түүний хүү Ж.Төмөрцэрэн болон бусад хүмүүс бичиж байв.

Ишданзанванжилын энэ зохиолд ийнхүү эрхэмсэг дээдсийн эдийн шуналыг илэрхийлэн хэлж шүлэглэснийг өнөөгөөс зуун жилийн өмнөх явдал мэт хуудам санаж хоцрогдсон сургаалын тоонд оруулахгүй биз ээ.

Ишданзанванжил тухайн цагийнхаа ноёдыг хорстол нь шүүмжилжээ. Түүний бичсэн нь:

*Шүр номин хөх цагаан жинс зэргийг нь үзвэл
Шинжлэлтэй төвшин мэргэн бат төрийг барилтай
Шунал өндөр ховдог их тааллыг нь үзвэл
Шийдэм зэвсэг бэлтгээд бэрх замыг хэрэлтэй”*

Өөрөөр хэлбэл өнгөн дүр нь мэргэн төрийг төвшин баригчийг шинжтэй атал үнэн дүр нь их замын дээрэмчин төрхтэй болчихсон буйг нь хэлжээ. Өдгөө зарим түшмэл авлига хээлд автаж ийм төрхтэй болсон байж ч магадгүй.

Тэд өөрсдөө эд хөрөнгөнд хөлбөрөн баярхаж доордос ардын гуцуу ядууг мэдэхгүй гутамшигтай байгааг Ишданзанванжил бас хэлсэн буй.

*“Үнэг ба хургаар илчигнэж /бигнэж дулаалаад гэсэн үг/
Үгүй боол чичрэхийг мэдэхгүй гутамшиг*

*Үзэм чихэр мах боорцгоор бэлжүүлэн агсаар***
Өлөн боол өлбөрөхийг болохгүй гутамшиг” гэжээ.*

*“Баян өргөн хишиг арвин сангийн байдлыг нь үзвэл
Буурайг тэтгэвч хүрэлцэхүйн аястай*

Бачимдах харгислах, хомголзохыг нь үзвэл

Бадарчилан хэсэвч өлбөрөхийн төлөвтэй” гэжээ.

Өөрөөр хэлбэл буурай ядуусыг тэтгэвч хүрэлцэхээр сантай атлаа бадарчилан хэсүүлэх шахсан шуналтай болсон гэдгийг нь улаан цайм хэлжээ.

“Тамга ба тэмдэгтэн эзлэхийг нь үзвэл

Таван зуун хэргийг ч нэгэн цагт ялгалтай

Тал, найрал, өнгө мөнгөнд самууран дагавал

Таван хэрэг таслах ч тамиргүй зөнөмүй”

гэх мэтээр төрийн хэргийг эдийн явдлаар шийдэх /Онцлов,Д.Т./ түшмэл ноёдын дүрийг илэрхийлсэн буй.

Лам, ноёд хэтэрхий сувдаглаж ёс төр, сахил санваар, сүсэг шүтлэгээ бохирдуулж түмэн олны дургүйцлийг төрүүлж, төр шашнаа дээдлэх сэтгэлийг бууруулж буйг Ишданзанванжил ихэд хурцаар шүүмжилсэн ил үгтэй зохиолоороо дээдэс ямбатны дургүйцлийг илэрхий төрүүлсэн юм. Түүний бичсэн нь:

“Гаслант орчлонгийн мөнх бусыг умартан

Ганц нэгэн биедээ зуун орон бэлтгээд

Гайхуулан элдэв эд дэлгэн шунан явагч

Газаргүй буянаа барах багш биш үү?”

“Амьтны сүсгээр өргөсөн хишгийг

Алт мөнгө шүр номин будаг хивс болгоод

Ам мэдэн далбилзаж зориг мэдэн явагч

Агсам багш алсдаа алдагдах бус уу”

“Ширээн дээр залахуй дор гэгээн багшийн дүртэй

Шилдэг морь унах нь наймаа панзын янзтай

Шилбэлзэн загнах нь зусар золбин байдалтай

Шинэ цагийн бурхан гэдэг ийм агсан /болсон / ажгуу”

“Ховор номлол хэлэх нь их номчийн дүртэй

Хонины мах идэх нь чоно нохойн шуналтай

Худалдаа наймаа дээр хятад мэт явагч

Хожимдоо найман тамын мөнх сав бус уу”

гэж шашны мяндагтан лам нарыг улайтал шүүмжилжээ. Үүнийг манай өнөөгийн шинээр сэргэсэн шашны хуврагууд санаж мэдэж явахад илүүдэхгүй буй заа. Хөдөө орон нутагт сааль идээний цагаар шилдэг морь унасан шинэ цагийн лам нар тохитой айлд ном уншиж, гүүтэй айлд тогоо нэрүүлэн “бүрхээрийн лам” нэрийг сонсож явахтай тааралдсан удаа бий бөлгөө. Тэр ч байтугай “хуруу урттай” болсон, тонуул хийсэн орхимжтон ч дуулддаг болсон байна.

Гүнгийн зуугийн гэгээнтэн энэ сургаалдаа лам хувраг нарыг “арилжаа худалдаан дээр хятад, мэт явагч” гэж шүүмжлэсэн байдаг нь тэр үед язгуурын монголчууд арилжаа худалдаагаар дагнаж амь зуух нь ховор их төлөв харийнхан, ялангуяа хятадууд наймаагаар аж төрдөг, түүнийг нь монголчууд таашаадаггүй байсны илрэл юм.

Худалдаа наймаа хийхийг үл таашаах үзэл санаа Д.Равжаагийн зохиолд ч байдаг. Ер нь өнгөрсөн зууны сүүлч үеийг хүртэл монголчууд тэр бүр худалдаа арилжааг үл

эрхэмлэж их төлөв таван хошуу малын ажлыг дагнаж ирсэн байдаг.”Монголын нууц товчоонд “ / МНТ-182/ арилжаа хийж яваа ганц хүн гардаг нь сартуул Хасан юм. 19 дүгээр зууны эцэс үеийг харуулсан Д.Нацагдоржийн “Учиртай гурван толгой” дуурьт ганц наймаачин гардаг нь төвд худалдаачин байдаг. Худалдаа наймааг төдийлэн үл таашаах нь монголчуудын эдийн засгийн уламжлалт сэтгэлгээний нэгэн содон онцлог болой.

Ишданзанванжилын шүлэг зохиолд ийнхүү анги давхаргын эд хөрөнгө, үзэл ахуйн ялгаа, шунахайрал, өнгө мөнгөний самуурлыг үзүүлсэн нь түүний эдийн засгийн үзэл санаа шүүмжлэлт хандлага, мөлжлөг дарлалыг сөргөсөн үзэл санааг нь илэрхийлжээ. Түүний энэ үзлийг эсэргүүцэгчид нь Эрхэмбилэг засаг шиг шүлгийг нь нухчин хаяж, дэмжигчид нь өнөө үеийг хүртэл уншин түгээсээр иржээ.

Ишданзанванжилын өвийг нэгтгэн нийтлэх цаг ирэх буй заа.

“Нэг үсгийн эрдэм” хэмээх сургаалыг Ц.Дамдинсүрэн гуай “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой” бүтээлдээ хэвлүүлсэн бий /Ц.Д.1959- 465 талд/.

Энэ сургаал нь хуучин монгол бичээчийн уламжлалаар бирага тавьж шинэ мөрнөөс эхэлсэн 25 бүлэг байна. Анх нэг үсгийн эрдэм гэж эхлэн улмаар хоёр, гурав, дөрвөн гэх мэтээр сургаалын агуулгыг тоочиж нэмсээр найм хүргэжээ. Эдгээрийн дотор зарим нь хоёр гурван зүйл сургаал өгүүлсэн байхад дөрвөн сургаалт бүлэг нь дийлэнх юм. Уул зохиолд бурхны шашны үзэл санаа, буян нүгэл энэ хойд насыг дурдаж буй боловч бүхэлдээ иргэнлэг ахуйн шинжтэй эдийн засгийн буюу аж ахуйн гэхээр сургаал нь дээрх сургаалуудын ижил бүү шунахайр, дэмий бүү бүрэлгэ, хурааж харамлах бус зохистой хэрэглэ гэсэн санааг агуулжээ.

*** **

Эцэст нь нэгтгэж үзвэл, монголын сургаалын зохиол дахь эдийн засгийн үзэл санаа нь бүхэлдээ зохист ухаалаг хэрэглээг эрхэмлэх, эд мөнгөнд шунаж хомголзохыг шүүмжлэх, хэмнэх, гамнахыг номлох, харам сэтгэлийг тэвчихийг сургах гэх мэт монгол ахуйгаас үүдэн гарсан үзэл санаа хийгээд буддын сургаал дахь сэтгэлгээг тусгасан байна гэж үзэж болно.

Мал ахуйг ихэд эрхэмлэх атлаа арилжаа худалдааг таашаахгүй үзэл санаа нэлээд элбэг байна. Энд эдийг хураах, мөнгө хүүлэх, хөдөлмөрийг мөлжих, зарцлах боолчлох, хөрш зэргэлдээх ард түмнийг түрэмгийлэх, нутаг дэвсгэрээс нь эмтлэх гэх мэт зүйлүүдийг огтхон номлон сургасангүй, гагцхүү хэн тэгш аж төрөх, өтгөс дордосыг ивээх, тэтгэх, асрах нигүүлсэхийг эрхэмлэх, ажил хөдөлмөрт шамдах, залхуурал, алгуурлалыг гэтлэх зэрэг өөдрөг суртахууныг номлосон байна.

Харин бурхны шашны үзлийн нөлөөгөөр эд хэврэг, мөнх бус гэх мэт үзэл санааг номлосон нь нэг бус байх ажээ.

Номзүй

- Ч.Дэмчигдорж. *Эрдэнэт толь хэмээх шастир оршивой*. УБ., 1995. /кирилл үсэгт Д.Дашбадрах буулгав/
- Ч.Бат-Очир “*Мандах нарны туяа*” хэмээх сургаал. УБ., 1992 /кирилл үсэгт А.Шагдар, Б.Осор нар буулгав/
- Тарба Бандид. *Ард түмний ариун ёсон оршивай*. Монгол бичгээр. УБ., 1991/Н.Дашзэвг лам хэвлэлд бэлтгэв/ “Хөх судар” хэвлэлийн хоршоо
- Гунгаажалцан. “*Эрдэнийн сан Субашид*” УБ., 1990. /Ц.Дамдинсүрэн, Дүгэржав нар 1959 онд хэвлүүлсэнийг Д.Төмөртоогоо дахин хэвлүүлэв/
- Шантидэва. *Бодисадын явдалд орохуй* УБ.1998 /Төвд хэлнээс орчуулж удиртгал тайлбар үйлдэж хэвлүүлсэн Т.Булган/
- Цагаан лянхуан баглаа хэмээх сургаал хийгээд түүний тайлбар оршивай. УБ, 1997 /Л.Тэрбиш, Ц.Даваасүрэн нар хэвлэлд бэлтгэжээ/
- Ц.Дамдинсүрэн. *Монголын уран зохиолын дээж зуун билиг оршивай*. УБ., 1959
- Д.Цэрэнсодном. *Монголын уран зохиол /XIII-XX зууны эх/* УБ., 1987
- Д.Равжаа. *Яруу найргийн цоморлиг*. УБ., 1992 /Д.Цагаан хэвлэлд бэлтгэв/
- Ц.Шүгэр. *Монгол модон барын ном*. УБ., 1991.
- Ж.Самбуу. *Мал аж ахуй дээрээ хэрхэн яаж ажиллах тухай сануулга сургаал*. УБ., 1987 хэвлэлд бэлтгэн найруулсан Д.Дамба.
- Ө.Дорж. *Малчнаа сануулах сэдэв*. УБ., 1934
- Ачлалт ном /Х.Лувсанбалдан хэвлүүлэв./*
- Ч.Алтангэрэл. *Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл I дэвтэр*. УБ., 1967
- Ноён хутагтын сургаалын аврахуй ачлал*. УБ., 2003
- Монголын нууц товчоо* УБ., 1990. Дөрөв дэх удаагийн хэвлэл. /Хуучин монгол хэлнээс Цэндийн Дамдинсүрэн орчуулав. ред.Ш.Гаадамба./
- Бат-Очирын Тогтохтөр. *Ажил ба сургуулийн зүйл*. УБ., 1998 Эрхлэн хэвлүүлсэн П.Хорлоо.
- Mongᠭol ᠰaᠭajin - u bičig*. Monumenta Mongolica. Tomus IV-I Centre for Mongol Studies. National University of Mongolia. УБ., 2004.